

## ӨВӨР МОНГОЛД ДЭ ВАНГИЙН ТОЛГОЙЛСОН ӨӨРТӨӨ ЗАСАХ ХӨДӨЛГӨӨН ӨРНӨСӨН НЬ

*Д.Зоригт\**

Өнгөрсөн зууны хориод оны сүүлээс Өвөр Монголын чуулган хошууд хятад ноёдын толгойлсон мужуудын захиргаанд орж, элдэв алба гувчуурт дарагдах болсон тул ард иргэд ДИУ-ын засгийн газарт өргөдөл айлтгал гаргаж эхэлсэн нь эсэргүүцлийн эхний хэлбэр байв. Гоминьданы засгийн газраас Өвөр Монголын талаар гаргаж байсан элдэв хууль, дүрэм, зааврууд монголчуудын нийгмийн байдалд өөрчлөлт гаргаж чадсангүй. Харин Өвөр Монголын нутагт хятад иргэд болон цэрэг оруулж, колоничлох явдал урьд байгаагүйгээр ширүүсэн, ард иргэдийн ахуй амьдрал хятадын цэргийн эрхтнүүд хоорондын дайны хөлд өртөн доройтох болов.

Өвөр Монголын Ардын хувьсгалт намын удирдлагаар 1928 онд Баргад, Гаадаа мээрэнгийн удирдлагаар 1929 онд Жирэмийн чуулганы Дархан хошуунд, дугуйлангийн хөдөлгөөний нэрт удирдагч Өлзийжаргалын удирдлагаар 1930-1931 онд Ордост ардын зэвсэгт бослого тэмцэл гарч Гоминьданы дарангуйллыг эсэргүүцэж байгаад дарагдсан байна. (1, т.30) Япончууд зүүн хойд Хятад ба Өвөр Монголын ихэнх хэсгийг түрэмгийлэн эзэлсэн байлдааныхаа ажиллагааг 1931 оны 9 дүгээр сарын 18-нд дайн зарлалгүйгээр эхлэхэд тэнд байсан Гоминьданы 150 мянган цэрэгтэй арми нь Зян Зиэши (Чан Кайши)-гийн тушаалыг биелүүлж, ямар ч эсэргүүцэл үзүүлсэнгүй. (2, т.33)

Энэ үеэр Цахар, Суйюань мужуудын монгол чуулган хошуудад өөртөө засах хөдөлгөөн идэвхтэй өрнөж эхэлсэн бөгөөд үүнийг Шилийн голын чуулганы дэд дарга Дэмчигдонров ван санаачлан удирдаж байлаа. Тэрээр Өвөр Монголын сурвалжит ван бөгөөд “үндэстний асуудлыг шийдвэрлэхээс өмнө дотоодын хувьсгалын тухай ярих ч хэрэггүй” гэдэг байжээ. (1, т.32)

Дэмчигдонров 1902 онд Цахарын чуулганы Шулуун цагаан хошуунд төрсөн хүн юм. Эцэг Намжилванчиг нь тухайн үеийн Өвөр Монголын Шилийн голын чуулганы дарга бөгөөд Сөнид баруун хошууны засаг төрийн дүүрэн жүн ван байв. Түүнийг мэндлэхээс өмнө эцэг нь гурван ч эхнэр авсан боловч хүү төрөөгүй тул өөрийг нь залгамжлах хүнгүйд гутарч, жар дөхсөн насандаа Цахарын чуулганы Шулуун цагаан хошууны нэгэн тайжийн охиныг хатнаа болгосноор хэргэм зэргийг нь залгамжлах хүү төрсөн аж. Дэмчигдонров төрсөн эхтэйгээ Цахарын чуулганы Шулуун цагаан хошуунд сууж байсан бөгөөд эцэг нь амьд ахуйдаа угсаа залгамжлах хүүтэйгээ ер уулзаагүй гэдэг. Нас ахисан өвгөн жүн ван бар жилтэй агаад цор ганц хүү нь хар бар жилд мэндэлсэн

\* Д.Зоригт - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

тул монголчуудын ярьдгаар харшлах шалтгаан гарахаас болгоомжлон эхтэй нь хамт суулгаж байжээ.

Эцгээ 1908 онд нас барахад зургаан настай байсан Дэмчигдонровыг чуулганы дарга нь Чин улсын төрд мэдүүлэн Сенид баруун хошууны засаг төрийн дүүрэн жүн вангийн суурийг залгамжлуулсан байна. Дэмчигдонров өөрт нь зориулж тусгайлан байгуулсан гэрийн сургуульд сурч, бичиг судар үзэхийн дээр Бээжин Датунаас урьж ирүүлсэн хоёр хятад багшаар “дөрвөн бичиг”, “таван ном”-ыг заалгаж байв. Түүнд мөн Кунз, Мэнзийн сургаалыг зааж, нас нь ахих тутам олон сонгодог зохиолуудыг албадан уншуулж, урьд үеийн хаад ноёд, жанжин, тэргүүн сайд нарын уламжлалт тэмдэглэлүүдийг судлуулж байжээ. Тэрээр багаасаа ном судар уншихаас гадна дуу хөгжим, ан ав, сур харваанд дуртай байсны дээр машин техникийн зүйлүүдэд сонирхолтой байв. (4, т.80)

Дундад Иргэн улс байгуулагдсаны дараа 1912 онд цэргийн эрхтэн Юань Шикай төрийн эрхийг булаан авч, Өвөр Монгол дахь ноёрхлоо бэхжүүлэн, ард түмний эсэргүүцлээс сэргийлэхийн тулд Монголын феодал эздийг биедээ татаж эхлэв. Тэр үед арван настай байсан Дэмчигдонров Сенид баруун хошууны хошой дүүрэн чин ван болов. Тэрээр 1919 онд арван найман нас хүрч, монгол ван гүн нарын суурь залгамжлах дүрмийн ёсоор Сенид баруун хошууны засаг хошой дүүрэн чин вангийн ширээнд залагдаж, хошууныхаа бүх хэрэг явдлыг биечлэн эрхлэх болжээ. (5, т.16) Шилийн голын чуулганы дарга Янсан нас ахиж, өвчин эмгэгтэй болсон учир 1924 онд тушаалаасаа бууж, дэд дарга Содномравдан уг албыг хаших болов. Ингээд хорин гурван настай байсан Дэмчигдонров Шилийн голын чуулганы дэд даргаар дэвшив.

Сунь Жуншань-ий улс ардын хуралдааныг хуралдуулах зорилгыг эсэргүүцэхийн тулд Дуань Чируй түр зуур төр барьж байхдаа 1925 оны 2 дугаар сард Бээжинд хийсэн хуралдаанд Дэ ван Шилийн голын төлөөлөгчөөр оролцож, зарим сонгууль хүлээсэн нь түүний улс төрд ойртох эхлэл болжээ. Тэрээр буцаж очоод өөрөө гол үүрэг гүйцэтгэх боломжтой улс төрийн бүлэг хүчнийг зохион байгуулж, настай болсон ван гүн нараас Монголын төрийн эрхийг булаах, улс төрийн ноёрхох байр суурийг эзлэх бэлтгэл ажлаа эхэлжээ. Тэрээр цэргийн хүчээ нэмэгдүүлэх зорилт тавьж, өвөг дээдсийн хуучин ёс, настай ван, гүн, дээд давхаргын лам нарын хатуу эсэргүүцлийг үл хайхран өөрийн биеэр сүм хийдүүдээр очиж, залуу лам нарыг хар болгохоор уриалахын хамт дотор газраас бичигтнийг залж, машин техник худалдан аваад хошуундаа ноосон нэхмэлийн жижиг үйлдвэр, мал аж ахуй эрхэлдэг нутгуудад сургууль, эмнэлгийн газар байгуулжээ. Мөн хошуундаа таван зуу гаруй хүнтэй амрыг хамгаалах зэвсэгт бүлгийг зохион байгуулсан бөгөөд 1926 онд дахин таван зуу гаруй цэрэгтэй “сахин хамгаалах анги” гэгчийг байгуулж мянга гаруй цэрэгтэй болсон

байна. Дэ ван хожим нь ордондоо буу зэвсэг засч хийх жижиг үйлдвэр хүртэл байгуулж, гар пулемёт, сум, дарь зэргийг хийх болсон байна.

Тэрээр 1929 онд Шахар мужийн гишүүнээр томилогдож, тэр жилдээ Банчин богдод бараа болж Ляонин мужийн Мүгдэн хотод Жан Сюэлян-тай уулзан түүнээс зэвсэг авахаар тохиролцсон байна. Энэ үедээ тэр “Монгол залуучуудын нам”-ын тэргүүн Гуй Дуфу-тэй уулзжээ. Тэрээр Дэ ванд “Ар, Өвөр Монголын өнөөгийн байдал их төлөв адил байгаа боловч Ар Монголын тусгаар тогтнол биелэлээ олсон нь шашны удирдагч Жибзундамба Монголын ард түмний гол шүтээн нь болсноос зорилгоо нэгтгэн, хүчээ төвлөрүүлж чадсанд байгаа юм. Өвөр Монголд гарсан хөдөлгөөнүүд удаа дараа ялагдсан нь тус тусдаа туг босгон уутанд хийсэн үхрийн эвэр шиг байгаагаас болж байна. Иймээс бүх хошууд хамтран хөрөнгө мөнгө хуримтлуулж, монгол нутагтаа Банчинд сүм бариулж, түүнийг Өвөр Монголдоо залан шашны удирдагч, гол шүтээн болговол Монголын хэрэг явдлыг эрхлэхэд бидэнд тус дөхөм үзүүлэх болно” хэмээн ярьсан нь түүний бодол санаатай яв цав нийцжээ. Ингээд энэ санаагаа хэрэгжүүлэх ажилдаа орж, бүх хошуудыг албадан шахаж зуун мянга гаруй мөнгөн зоос цуглуулан өөрийн нутаг Сөнид баруун хошуу болон Шилийн голын чуулганы дарга Содномравдан вангийн нутаг Үзэмчин баруун хошуунд тус тус сүрлэг том сүмийг Банчинд барьж өгчээ. (3, т.11)

Япончууд 1931 онд Хятадын зүүн гурван мужийг зэвсгийн хүчээр эзлээд дараа жилийн 3 дугаар сарын 1-нд “Манж улс”-ыг байгуулсан билээ. Дараа нь тэд Өвөр Монголын зүүн хэсгийг булаан авч, баруун нутгийг гартаа оруулах явуулгаа идэвхжүүлж эхлэв. Энэ үед Дэ ван япончуудтай холбоо тогтоох бодолгүй байснаар үл барам тэдэнтэй зэвсэг барин тэмцэхэд бэлтгэж байлаа. (2, т.32)

Зян Зиэши (Чан Кайши) 1932 оны намар өөрийн ойр дотны гурван хүнийг Монгол-Түвэдийн хорооны тусгай гишүүний хамт Наньжингаас Сөнид баруун хошуунд явуулж, Дэ вантай уулзуулсан бөгөөд тэрээр зочлыг ихэд хүндэтгэн дайлж буцаасан гэдэг. Тэдгээр хүмүүс нь Зян Зиэши-д танилцуулсан мэдээлэлдээ “Хожим нь Монголын хэрэг явдлыг хариуцах хүн нь энэ залуу болох нь лавтай” гэж дурдсан байна. Төлөөлөгчдийг буцсанаас хойш удалгүй Зян Зиэши түүнийг Ухань-д ирж уулзахыг урьсан цахилгаан ирүүлжээ. Дэ ван Ухань-д очиж Зян-тай уулзан монгол морьт цэргийн дивиз байгуулах талаар ярилцаж, түүний орон тоо, төсөв, зэвсэглэл зэргийн тооцоог холбогдох хүмүүстэй нь хамтран хийсэн байна. (10, т.23)

Тэрээр дараа нь Зян Зиэши-тэй Наньжинд дахин уулзаж монгол дивиз болон цэргийн сургууль байгуулах зэрэг асуудлыг ярилцан зөвшөөрүүлсэн бөгөөд төвийн улс төрийн сургуульд сурч байсан монгол оюутнуудтай уулзаж, тэдэнд гүнзгий сэтгэгдэл төрүүлж чадсан байна. Мөн

тэр үед Наньжинд очоод байсан Дилав хутагттай уулзсан бөгөөд түүнээс Өвөр Монгол өөртөө засч болох эсэхийг асуухад хутагт “Ар Монгол нэгэнт тусгаар тогтнох буюу өөртөө засч болж байхад Өвөр Монгол яагаад болдоггүй юм” гэж хариулсан гэдэг. Дилав хутагтын энэ үг түүнд маш хүчтэй нөлөөлсөн тухай тэр хожим дурссан байдаг. (4, т.12)

Дэ ван 1932 оны өвөл Наньжингаас Бээжинд ирж, их дээд сургуулиуд болон Монгол-Түвэдийн сургуульд сурч байгаа монгол оюутнууд, тэнд сууж буй монгол сэхээтнүүдтэй уулзаж, тэдэнтэй ойртох ажил хийв. Энэ үед Өвөр Монголын зарим залуу ван, гүн болон олон сэхээтэн залуус түүнийг дэмжиж, “Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн”-ийг үүсгэхэд гол тулгуур хүч болж байв. Тэрээр 1933 оны хавар Сөнид баруун хошуун дахь вангийн ордондоо монгол цэргийн кадр хүчний сургууль байгуулж, Бээжингээс дагуулж ирсэн оюутнуудаа болон чуулган хошуудаас ирүүлсэн дал гаруй залуусыг эндээ сургаж боловсруулав. Ухань, Наньжингаас олж ирсэн буу зэвсгээ бүгдийг энэ хүмүүстээ тарааж өгчээ. (5, т.7)

Дэ ван Банчин богдын дэмжлэгийг авахаар бодож байсан тул Шилийн голын хошуудаар ном уншиж ирээд байсан түүнтэй уулзаж, Шилийн гол, Улаанцав, Их зуу гурван чуулган хамтран монгол хошуудаа хамгаалах арга сүвэгчилж байгаа тул үнд нь туслахыг хүсэв. Банчин богд хамтран нийлж монгол нутгаа хамгаалах санааг нь хамгийн сайн арга гээд улс төрийн асуудлаа монголчууд та нар өөрсдөө шийдэх ёстой учир би та бүхнийг төлөөлж болохгүй гэсэн санаагаа хэлж авралдаа даатгана гэв. Дэ ван Банчин богдыг Үзэмчин баруун хошуунд Содномравдан вантай тэр даруй уулзуулж, ятгуулан зөвшөөрүүлээд Шилийн голын чуулганы даргын нэрээр Улаанцав, Их зуугийн чуулганд Монголын хэргийг хамтаар зөвлөлдөх тухай албан бичиг явуулав. Ингээд Улаанцавын чуулганы Халх баруун хошууны Бат хаалга (Байлин мяо) сүмд очиж, чуулганы дарга Ёндонванчиг чин вантай уулзан Өвөр Монголын өөртөө засах явдлыг санаачлан сэдэх тухай асуудлаар зөвшилцөв. Яг энэ үеэр Монгол-Түвэдийн хорооны Монголын хэрэг эрхлэх газрын дарга тэргүүтэй хүмүүс Шилийн голын чуулганд “ухааруулан номхотгох” ажлаар ирэхэд Дэ ван тэднээр Ёндонванчиг ванг ятгуулахад тэрээр Бат хаалга сүмд ирж, 1933 оны 7 дугаар сарын 26-ны өдөр өөртөө засах тухай асуудлаар анх удаагийн хуралдаан болсон байна. Хуралдаанд Шилийн голын чуулганы олонхи хошуудын, Улаанцавын чуулганы Дархан, Дөрвөд хошууны төлөөлөгчид оролцжээ. Ёндонванчиг, Дэмчигдонров нар удирдан гурван өдөр хийсэн уг хуралдаанаар Өвөр Монголын өөртөө засах засгийн газар байгуулахыг зөвшөөрүүлэхээр төв хороонд шаардлага тавих, хугацаа сунган хоёрдахь удаагийн хуралдааныг хийж, түүндээ чуулган хошуудын ван гүн болон гадаадад суугаа монголчуудыг урьж оролцуулах шийдвэр гаргав. (6, т.21)

Дэ ван цахилгааны нооргийг бичээд хошуундаа ирсэн хойноо холбогдох хүмүүстэй дахин нягтлан ярилцаад “Өөртөө засах” гэдэгт “дээд хэмжээ” гэсэн үгийг нэмсэн байна. Уг цахилгаан мэдээг 7 дугаар сарын 27-нд тараасан бөгөөд түүнийг Гоминьданы Төв хорооны гүйцэтгэх комисс, Засгийн газрын Засаг захиргааны хороо, Цэргийн явдлын хороо, Монгол-Түвэдийн хороо, Зөвлөхүүдийн ерөнхий хэлтэст тус тус хүргүүлсэн байна. Цахилгааны агуулга нь “Ойрын жилүүдэд улс орон маань дайн дажинд өртөж, хил хязгаар хорогдон, гадаадын түрэмгийлэл өдрөөс өдөрт ширүүсч байна. Манай Монгол орон Япон, Оростой хөршилж байгаа учир хохирол сүйдэл нэн хүнд болов. Уудам цэлгэр нутгийн дорой буурай үндэстэнд хариуцан эсэргүүцэх чадал үгүй мөртөөн сахин хамгаалах арга ч алга. Арван жилийн турш Ар Монгол Орост мөлжигдөн, Жирэм ба Хөлөнбуйр чуулган Японд эзлэгдэж, ойрд Зост, Зуу уд зэрэг чуулган мөн залгаа залгаагаар сөнөх шахсан бүлгээ. Үүнд баруун Монгол доргиж, Дундад гүрэн донслон хугтаны ир дээр байх мэт аюул түгшүүртэй болсон тул улс даяар зовнимой. Дорой буурай манай монгол үндэстэн харийн талхигдлыг хүлцэж тэсвэрлэн хувиа сахих л боллоо.

Гэвч орчимд хүчирхэг хөрш улс цөмөөр түрэмгийлэн ирсэн тул хэрэг байдлыг агшин зуур ч алгуурлаж болохгүй болжээ. Аюулыг мэдэхгүй амар суусаар байтал мөхөх сэхэхийн аюул нэгэнт тулгарав. Байдал тулгам тэсвэрлэхүйеэ бэрх, аван хариуцах арга үгүй, хэрэв бүх хүчээ шавхан өөрсдөө шийдэхгүй болбоос аль нэгэн өдөр хүчит дайсан довтлон ирэхлээр газар бүхэн үнсэн товрог болж, дорой буурай Монголын хил лавтайяа бага багаар хорогдож, төв хороонд ч зовлон гаслан тулгарах буй. Хил хязгаарын орон сэдэрмэгц манай Монголын мөхлөөс болж бүх улсын ах дүү нарт уршиг татаж, бүх улсын ард түмэнд гай зовлон учруулмой.

Манай Сун ерөнхийлөгч ард түмний өөртөө засахаар суурь болгон дорой буурайг тэтгэн дэмжихээр үүрэг зорилгоо болгосон ажгуу. Түүнийг сод мэргэн гэрээс сургаалыг үеийн үедээ журамлаваас зохимой. Төв хороо цэргийн явдалдаа холхийг бодолхийлэх чөлөө завгүй баймой. Иймийн тул манай монголчууд зоригтойгоор босолцон ерөнхийлөгчийн сургаалыг журамлан, өөртөө засах ба тусгаар тогтнохоор чармайхгүй байж болно гэж үү.

Өвөр Монголын бүх дарга ноёдын хуралдаанаас дээд хэмжээгээр өөртөө засч, Өвөр Монголын өөртөө засах засгийн газар байгуулан, бүлгэмдэн давшихыг ахиулан төв хорооны хүрэлцэхгүй талыг нөхвөрлөх хэмээн тогтлоо. Цэргийн явдал ба гадаад харилцаа зэрэг нь улсын байгууламжид холбогдох тул манай монголчууд чадвар мөхөс, хүч бага, төв хорооны тусламжид найдсаар ирсэн тул үхэх сэхэхийн зангилаа үед нэн юуг өгүүлэх ажгуу. Манай монголчуудын зовиур зүдгүүрийг ойлгож, дорой буурайг хөөрхийлөн хавсарч, удирдан зоригжуулж, хүрэлцэхгүй

талыг нөхвөрлөн өөртөө засах ба тусгаар тогтнох зориг санааг дэмжиж хүчирхэгжихээр чармайх санааг ахиулан, зуршлыг өөрчилж, засгийг шинэтгэх болов уу. Ийн болбоос дээрээ төв хорооны засгийг сайжруулах бодолтой, доороо манай монголчуудын өөртөө засахыг эрмэлзсэн сэтгэлтэй байж, таван үндэстний ард түмэн харилцан туслалцаж, аюул түгшүүрээс мултарч улсын хил ч бэхжих буй заа. Энэ хэмээвээс монголчуудын аз завшаан, улс орны аз завшаан болмой...” (7, т.56)

Энэ цахилгаан Гоминьданы засгийн газрыг доргиож, дотоодын олон сонин сэтгүүлд нийтлэгдэн, улс даяар ихээхэн анхаарал татав. Гадаадын зарим сонины сурвалжлагч нар Дэ ван нартай ирж уулзах болсон байна.

Гоминьданы засаг захиргааны удирдлагаас Дотоод явдлын яамны сайд болон Монгол-Түвэдийн хорооны дарга нарт үүрэг өгөхдөө энэ хэрэг явдлыг Дэ ван жолоодож байгааг дурдаад түүний явуулгыг илчлэхээс гадна “өршөөл, сүрдүүлэл” хоёрыг хэрэглэн тэднийг нэгэн цогц хүчин болгохгүй байхад анхаарахыг зөвлөсөн байна. Мөн үүний ард гадаадын ямар нэгэн хүч байгаа эсэхийг тодруулахад нэлээд анхаарч байв. Байдлыг ажиглуулахаар Бат хаалга сүм рүү холбоо барих хэрэгсэлтэй хүн томилон явуулснаар барахгүй уг хүнээрээ Улаанцавын чуулганы дарга Ёндонванчиг ванг уг хуралдаанд оролцохгүй байхыг ятгуулсан байна. Мөн холбогдох зарим хүн Монголын “дэлгэрэнгүй ухуулах элч” Жанжаа гэгээнийг ятгаж, Зян Зиэши болон Гоминьданы Засаг захиргааны хороо, Монгол-Түвэдийн хороонд нууц цахилгаан ирүүлж “Өвөр Монголын өөртөө засахыг эд хөрөнгө зэр зэвсгээр тусалж, заан жолоодож байгаа хүн бол Банчин мөн. Түүнийг даруй түргэн баруун гурван чуулганаас гаргаж, түүгээр энэхүү асуудлыг шийдвэрлүүлэх болов уу” гэсэн байна. Жанжаа гэгээн 10 дугаар сарын 2-нд Утайгаас Бээжинд ирээд эдгээр чуулган хошууны ван гүн нарт “буруу замаар бүү явагтун” гэж уриалсан цахилгаан илгээв.

Бат хаалга сүмд өөртөө засах асуудлаар хоёр дахь хуралдааныг мөн оны есдүгээр сард хийхдээ Дэ ван гол эрх баригчдыг оролцуулах зорилгоор Банчин богдыг Шилийн голын чуулганаас энд ирүүлж, түүнд тусгайлан ордон барьж өгсөн байна. Бэлтгэл ажлаа дуусгаад 10 дугаар сарын 9-ний өдөр хуралдаанаа эхлэв. Ёндонванчиг ван, Дэ ван нар уг хэлж дараа нь “Өвөр Монголын өөртөө засах засгийн газрын зохион байгуулалтын хөтөлбөр” болон өөртөө засахыг шаардсан айлтгалын цахилгаанаа ярилцан баталсан байна.

Наньжин дахь Гоминьданы засгийн газар Дэ ван нарын дээд хэмжээгээр өөртөө засах тухай шаардсан өргөдлийн цахилгааныг тэдний Дундад улсаас салж хагацах тийш хандсан байдал гэж үзээд асуудал нэлээд ноцтой болсныг ойлгов. Монгол-Түвэдийн хорооны байнгын гишүүдийн хурлыг зориуд хуралдуулаад дараах байдлаар ажиллахаар тохиров. Үүнд:

Гишүүн Ли Фэнган-г Сахарын чуулганы дарга Зодовжав, амбан Ням-Осор нартай хамтран ажиллуулахаар томилов. Мөн Суйюань мужийн бүх чуулган, хошуудын ван гүн нарыг хуралдаанд оролцохгүй байхыг ягтуулахаар тусгай ажилтан ба дэлгэрэнгүй ухуулах элч Жанжаа гэгээнд цахилгаан илтгэв. Хорооны хоёр зөвлөхийг гурван гишүүний хамтаар Монголын өөртөө засах бэлтгэл комиссын гаргасан төслийг судлуулахаар тогтов.

Тухайн үед Сахар мужийн тэргүүлэгч Сун Зюань Наньжинд нууц цахилгаан явуулж, энэ ажиллагаа нь хоёр вангийн сэтгэл санаа хувирч тусгаар тогтнох гэсэн санаа болохоос биш үүнийг монгол үндэстний ард иргэд бараг мэдэхгүй байгаа гээд эл байдлыг тагнуулахаар монгол хүн хуралд томилж явуулснаа дурдсан байна. Тэрээр төв хорооноос Дэ ванд алдар цол олгож, Бээжинд аваачиж алба хаалган аль болохоор аргадан татаж, санаа сэтгэлийг нь хувиргах хэрэгтэй гээд мөн төвөөс Монголын байдлыг сайн мэддэг том албан тушаалтныг ухуулан номхотгох ажил хийлгэхээр яаралтай томилон явуулж, бүх ван гүн нарт учрыг ойлгуулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлжээ. Мөн чандлан хязгаарлаж болох боловч Япончууд хөшигний араас жолоодож байгааг харгалзан үзэх хэрэгтэйг мөн тэмдэглэсэн байна.

Үүний зэрэгцээ Суйюань мужийн тэргүүлэгч Фу Зуои Улаанцав, Их зуугийн бүх хошуудад “тусгай хүмүүс”-ийг томилон явуулж, ван гүн нарыг Дэ вангийн зохион байгуулж буй хуралдаанд очуулахгүй байхад чиглэсэн ажлыг хатуу, зөөлөн олон аргаар хийж байв. Тэрээр Дэ ван газраа өөрчлөн Шилийн голын чуулганд нууц хуралдаан хийж байгаа тухай мэдээлэл олсноо төвд мэдэгдсэн байна. Мөн энэ ажилд Жанжаа гэгээн, Банчин богд нарыг хэрхэн ашиглах талаар тодорхой санал солилцож, нэлээд зүйл хийсэн байна. Эдгээр олон талт ажиллагаануудын үрээр Шилийн гол, Их зуу, Улаанцав чуулганы бүх хошуудын ван гүн нарын дотор Дэ вангийн өөртөө засах хөдөлгөөнийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх гэсэн эсрэг тэсрэг байдал бий болов. (7, т.76)

Дэ ван өөртөө засах хуралдаан нь амжилт олохгүй байж болох аюул буй болж байгааг мэдээд Бээжин, Наньжин зэрэг хотуудад суугаа өөрийг нь халуунаар дэмждэг монгол залуучуудаар уриалга гаргуулж, Өвөр Монголын өөртөө засах явдалд бүх талын дэмжлэг олохыг чармайв.

Аравдугаар сарын 17-нд Гоминьданы засгийн газар, Монгол-Түвэдийн хороо, Зөвлөхүүдийн ерөнхий хэлтэс зэрэг газрууд хамтран хуралдаж, Өвөр Монголын өөртөө засах асуудлыг шийдвэрлэх тухай гурван зүйлтэй төсөл гаргав. Хуралдаанаас Дотоод хэргийн яамны сайд Хуан Шаохун Монгол-Түвэдийн хорооны дэд дарга Жао Пилян нарыг тусгай элчээр томилж, энэхүү гурван төслөөр үндсэн зарчим болгож, Өвөр Монголд ухуулан номхотгох ажил хийлгэхийн хамт өөртөө засах асуудлыг зөвшилцөн шийдвэрлүүлэхээр тогтов. Мөн “Өвөр Монголын ард түмэнд өгөх заавар”-

ыг монгол, хятад хэлээр яаравчлан хэвлүүлсэн байна. Энэхүү баримт бичигт Хятадын удирдлагаас үндэстнүүдийн талаар баримталж буй бодлогыг тайлбарлан хил хязгаар нутгийн байдал нэн түгшүүртэй байгаад засгийн газар сэтгэл ихээр зовниж буйгаа илэрхийлээд “Эдүгээ Өвөр Монголын ард түмэн маань өөртөө засахыг хүсч байхад төвийн засгийн газар нь эс зөвшөөрөх санаа үгүйгээр үл барам харин туйлын дуртайяа хавсран жолоодож, биелүүлэхийг зоримой. Гагцхүү өөртөө засахын урьдал нөхцөл болбоос ард түмэн улс төрийн талаар нэлээд боловсрол хүмүүжилтэй, аж ахуй дээрээ нэлээд элбэг дэлбэг байваас зохимой. Өвөр Монголын газар орны сурган хүмүүжил, соёл, жич аж ахуйн амьдралыг хөгжүүлэх нь чухал бөлгөө. Улс төрийн боловсрол хүмүүжил нэн ч бэлтгэл хүрэлцэхгүй байх тул хэрэв дээд хэмжээгээр өөртөө засахад хүрвээс мөн ч хий хоосон нэр төдий болох бөгөөд ард түмэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй, аж ахуй ч шаардлага хэрэгцээнд тохирч чадахгүй ажээ. Цаашилбал ач тус үл гарах мөртөөн үймээн түйвээн дэгдэх болмой. Энэ болбоос засгийн газраас тодорхой мэдэж байгаа бөгөөд ихэд санаа зовж байх явдал болой. Бие биеэ хамгаалж, гадаадын түрэмгийллийг эсэргүүцэх хүчнийг бүрэлдүүлэн өөртөө засах чадвартай болгоод хожим хойшдоо манай намын “улс байгуулах хөтөлбөр”-т заасан ёсоор жинхэнэ орон нутгийн өөртөө засахыг явуулмой. Монголын ард түмний зан заншил, үг хэл, шашин суртахуун нь дотор газар лугаа адил бус тул засгийн газраас онцгойлон бодолхийлээд мужийн засаг захиргааны системийн доор монголчуудын улс төрийг байнга эрхэлдэг байгууллагыг онцгойлон байгуулж, анхны алхмын өөртөө засахыг туршин явуулснаар мөргөлдөөний хор гэмийг арилгаж чадахаар үл барам мужийн засгийн газрын хүрэлцэхгүй талыг ч туслан хавсарч, хамтран ажиллаж амжилт олж чадмой” гэх зэргээр ухуулсан байна. (7, т.85-86)

Дотоод хэргийн яамны сайд Хуан Шаохун, Монгол-Түвэдийн хорооны дэд дарга Жао Пилян нар Монголын байдлыг сайн мэдэх Кун Чинзун нарын гурван ажилтны хамт 10 дугаар сарын 21-нд Наньжингаас мордож, Бээжингээр дайрахдаа цэргийн болон холбогдох зарим байгууллагын удирдах хүмүүстэй санал солилцож, тэнд байсан Жанжаа гэгээнтэй ярилцсан байна.

Энэ үеэр Дэ вангийн тугийн дор тангараг өргөсөн Бээжингийн бүлэг монгол залуус болон манай улсаас тэнд очсон ван Наянт зэрэг хүмүүс Хуан нарыг ирэхэд Ар, Өвөр Монголын Бээжин дэх нутаг нэгтнүүдийн эвлэл, Бээжин дэх Монгол оюутнуудын холбоо, Монголын тэтгэмжийн эвлэл зэрэг газруудын нэрээр өөртөө засах асуудлаар саналаа хэлэхийн хамт газар сайгүй уриалж байв. (8, т.12)

Хуан Шаохун нар 11 дүгээр сарын 10-нд арван долдугаар армийн командлагч Сюй болон хуягт тэрэгний ангийн хамгаалалттайгаар одоогийн Хөххотоос Бат хаалга сүмд хүрэлцэн ирэхэд ван гүн нар



тэднийг Чин улсын үед дээдсийг хүлээн авдаг байсан уламжлалт заншлаар угтан авч, хонины бүхэл мах тавин дайлжээ. Төлөөлөгчид ван гүн нарт бэлэг сэлт тараагаад Бат хаалга сүмд очиж мөргөл үйлдэх зэргээр монголчуудын сэтгэлийг засахаар чармайв. Банчин богд энэ сүмийн мянга гаруй ламыг дагуулан Хуан нарын буудалласан газарт ирж ном уншсанд тэд лам нэг бүрт мөнгөн зоос барьсан аж. Дараа нь Улаанцавын чуулганы дарга Ёндонванчиг төлөөлөгчдөд зориулан бөх барилдуулж, морь уралдуулан том наадам зохион байгуулсан байна.

Угтах ёслолын дараа Дэ ван нар Өөртөө засах хуралдааны тэргүүлэгчдийн нэрийн өмнөөс 12-ны өдөр “Өвөр Монголын өөртөө засах засгийн газрын зохион байгуулалтын хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдээ төвд мэдүүлж бүртгүүлэхээр Хуан Шаохун нарт өргөн барихад тэд үүнийг нь төвийн чиглэлээс хэтэрхий зөрөөтэй гээд хүлээн авсангүй бөгөөд төвийн гурван зүйлийн төслийн агуулгыг тодорхойлон тайлбарлаж, Дэ ван нарт дахин судалж үзэхийг зөвлөв.

Дэ ван уг төсөл дэх Монголын орон нутгийн засаг захиргааны системийг өөрчлөх тухай заалтыг хүлээн авах боломжгүйг илэрхийлээд өөртөө засах засгийн газар байгуулж, Цахар Суйюань хоёр мужийг үгүйсгэхээр хатуу шаарджээ. Тэрээр “Төвийн засгийн газрын шууд харьяанд дээд хэмжээний нэгдсэн Өвөр Монголын өөртөө засах засгийн газар байгуулахыг зөвшөөрүүлэхээр эрс шаардана” гэхэд Хуан Шаохун “Хилийн мужийн засгийн газарт шууд харьяалагдах орон нутгийн хуваарьтай Өвөр Монголын өөртөө засах засгийн газар байгуулахыг л зөвшөөрнө” гэв. (9, т.11)

Хуан болон Дэ вангийн хэлэлцээр зогсонги байдалд орсонд хоёр тал төлөөлөгчдөө томилон 16-ны өдөр хуралдахад Өвөр Монголын нэгдсэн хамгийн дээд байгууллага-Өөртөө засах засгийн газрыг зохион байгуулахыг Дэ вангийн талын төлөөлөгчид зорилтоо болгож, арван нэгэн зүйл бүхий ярилцах хөтөлбөрийг дэвшүүлэв. Нөгөө тал асуудлыг цаашид хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хэлэлцээр үр дүнгүй өндөрлөсөн байна. Хуан энэ тухай сонсоод Дэ вантай дахин ярилцсан боловч үр дүн гарахгүйг мэдээд “хойш суух” байр суурьт шилжив.

Тэд Дэ вангийн хүчийг задлахын тулд нэг талаар Их зуугийн чуулганы дэд дарга Алтан-Очир зэрэг хүмүүст Улаанцав, Их зуу хоёр чуулганы ван гүн нарын дунд эвсүүлэх ажиллагаа хийлгэхээр далдуур захиж, нөгөө талаар Бээжинд буцах гэж байна гэсэн цуу тарааж, дагалдах хүмүүстээ мэдэгдэв. Ийм арга хэрэглээд Ёндонванчиг зэрэг хүмүүсийг шаардан Их зуу, Улаанцав хоёр чуулганы төвийг сахисан хэсэг ван гүн нарыг Дэ вангаас холдуулан төвийн төслийг хүлээн авах нөхцөл бүрдүүлэхээр тооцжээ. Бат хаалга сүмд байгаа ван гүн нарын дотор ийнхүү хоёр бүлэг буй болж, Суйюань мужийн Улаанцав, Их зуу хоёр чуулганы төлөөлөгчдийн олонхи нь төвийн төслийг зөвшөөрч, Дэ ванг дэмжигч цөөн тооны залуу ван гүн нар эсэргүүцэж байлаа.

Ёндонванчиг зэрэг хүмүүс Хуан-ыг Бат хаалга сүмээс мордох гэж байгаа гэсэн цууг сонсоод Банчин богдоор түүнийг ятгуулан үлдээлгэх ажил хийж, хэлэлцээг үргэлжлүүлэх болов. Тухайн үед Дэ ван маргалдаан ширүүсч, аль алиндаа дийлдэхгүй болсон ба хэлэлцээр тасрах тийш хандаж, өөрөө ганцаардах байдалтай болсноо мэдээд Цахар, Суйюань хоёр мужийг үгүйсгэх шаардлагаа орхиж, өөртөө засах дүрмийн арван нэгэн зүйл бүхий тогтоолыг боловсруулав. Хуан Шаохун нар үүнийг нь үзээд нэгдүгээр зүйлийн “Өвөр Монголд нэгдсэн хамгийн дээд өөртөө засах байгууллагыг байгуулж, Өвөр Монголын өөртөө засах засгийн газар гэж нэрлэнэ” гэснийг мөн л зөвшөөрсөнгүй. Тэд Ёндонванчиг ванд хэлэлцээг эвдэхгүй байхыг ятгаж, мөн олон явуулга хийсэн байна. Хуан яриандаа Өвөр Монголд хоёр онцгой орны засгийн газар байгуулахыг зөвшөөрч болох тухай санааг илэрхийлэхэд Ёндонванчиг ван тэр даруй дэмжив. Дэ ван түүний нэгэнт зөөлөрснийг мэдээд хатуурхвал дотоодлоо хагарал гарахаас болгоомжлон мөн эсэргүүцэж чадсангүй. Ингээд “хөх” болон “хөхөгчин” нэртэй хоёр зүйлийн дүрмийн төслийг хамтран боловсруулсан байна.

Дэ ван Ёндонванчиг нар төвийн төлөөлөгчдийг үдэх найр хийж, монгол наадам үзүүлсэн бөгөөд Хуан нар нь Монголын төлөөлөгчдөд замын зардал өгч, Банчин богдыг залж ном уншуулан, Бат хаалга сүмийн лам нарыг аргадан татахаар мөнгө зоос бэлэглэв. Суйюань мужийн эрх баригчид болон Хуан Шаохуны санаачилгаар монгол хятадын “сэтгэлийг нийлүүлэх” зорилгоор 11 дүгээр сарын 28-29-нд одоогийн Хөххотод Монгол Хятадын хамтарсан их хурлыг хуралдуулав. Энэ хуралд Суйюань мужийн хилд багтах Улаанцав, Их зуу хоёр чуулганы бүх хошуудын ван гүн нар хатдынхаа хамт уригдан очсон бөгөөд 250 гаруй хүн оролцжээ. Их хурлын үеэр цэргийн жагсаал хийж, зэвсгийн эрдмийн үзүүлбэр толилуулж, бөх барилдуулан морь уралдуулсан байна.

Дэ ван Монголын нэгдсэн өөртөө засах эрхийн төлөө бүх газраас дэмжлэг эрж, “үднээс хойш биеэ Монголын төлөө зориулж, ямар ч үрэгдэл сүйдлийг хайхрахгүй, ямар ч хүчир хэргээс айхгүй, нэг сэтгэл нэг зүрхээр нэгдсэн өөртөө засахаа биелүүлж, монгол үндэстнээ сэргээн хөгжүүлнэ” гэж андгайлсан байна. Ингээд Өвөр Монголын өөртөө засах явдлыг зөвшөөрүүлэхээр Наньжинд очих төлөөлөгчдийг бүх чуулган, хошуудаас сонгон гаргах мэдэгдэл тараав.

Хуан нар буцаж ирээд ажлаа танилцуулсны дараа 1934 оны 1 дүгээр сард Гоминьданы төв хороо улс төрийн хуралдаан хийж, Өвөр Монголын өөртөө засах бүх асуудлын тухай шийдвэрээ Хуулийн танхимд хянуулахаар өгч, дараагийн хуралдаанаар Хуаны бичсэн Цахар Суйюань хоёр мужид тус бүр нэг өөртөө засах орон байгуулах тухай саналыг хоёр өөртөө засах орон байгуулах гэж өөрчлөөд бусад зүйлийг хэвээр үлдээж, “Өвөр Монголын өөртөө засах тухай арван нэгэн зүйлийн

арга”-ыг тогтоон батлав. (9, т.18) Энэ үед Монголын хүсэлт тавих бүлгийн төлөөлөгч Ням-Осор, Сэнгэринчин, Хас-Очир нар Наньжинд ирээд байв. Тэд сая батлагдсан тогтоол нь Бат хаалгад боловсруулсан баримт бичгүүдээс ихээхэн зөрөөтэй байгаад дургүйцэж, эсэргүүцэх таван нөхцлийг дурдаад уг баримт бичгийг хүчингүй болгохыг шаардсан байна.

Засаг захиргааны хорооны дарга Ван Зянвэй төлөөлөгчидтэй уулзан эелдэг зөөлнөөр тайлбар хийж, уг асуудлыг тэр даруй дахин авч үзнэ гэдгээ илэрхийлжээ. Тэд том хэмжээний дайллага зохион байгуулж Наньжинд байгаа бүх монгол хүмүүсийг төлөөлөгчдийн хамт урьсан бөгөөд үнд зуу гаруй хүн оролцсон байна. Энэ арга хэмжээний үеэр Монголын төлөөлөгчид Өвөр Монголын өөртөө засах таван нөхцлөө (7, т.125-126) дахин тайлбарласан байна. Үүнд нь өөртөө засах хэрэгцээ, бололцоо болон өөртөө засах үндэс баримт, үнэн байдал, ашиг тус зэргийг багтаажээ. Мөн Өвөр Монголын бүх чуулган хошуудын төлөөлөгчдийг тэргүүлж явсан хүмүүс засаг захиргааны хорооныхонтой олон удаа уулзаж ярилцсаны эцэст “Нэгдсэн Монголын өөртөө засах гишүүдийн хурал байгуулахыг зөвшөөрвөл Наньжинд ирсэн төлөөлөгчдийн шаардлагыг хангаж чадах бөгөөд энэ асуудлыг амархан шийдэх боломжтой” гэсэнд тэд “Тэгвэл та нар нэг өөртөө засах төсөл гаргаад өгвөл холбогдох хүмүүсээр судлуулж, төвийн улс төрийн хуралдаанд оруулж ярилцуулья” гэсэн байна.

Төлөөлөгчид бас нэг өөртөө засах төсөл бэлтгээд Ван Зянвэй-д өгөхөд тэд “Монголын өөртөө засах найман зүйлийн зарчим” гэгчийг (7, т.130-131) боловсруулан Наньжингийн засаг захиргаанд Зян Зиэшигийн саналыг авахаар хүргүүлэв. Зян Зиэши үүнийг нь үзээд зөвхөн “Монголын өөртөө засах” гэдгийн дунд “орон нутгийн” гэсэн хоёр уг нэмээд бусад зүйлийг нь Ван Зянвэй-гийн боловсруулснаар үлдээсэн байв. Наньжинд ирсэн монгол төлөөлөгчид уг баримт бичгийг урьдын өөртөө засах аргатай онц зөрөөгүй гэж үзээд хүлээн зөвшөөрөв. Ингээд Өвөр Монголын өөртөө засах асуудлын анхны алхам шийдвэрлэгдсэн байна.

Наньжинд очсон төлөөлөгчид будаж ирсний дараа 4 дүгээр сарын 3-нд Ёндонванчиг ван, Дэ ван нар Бат хаалга сүмд урьдаар очиж, тушаалт ажилдаа ороод 12-ны өдөр “Монголын засгийн явдлын зөвлөл”-ийн дарга Ёндонванчигийн нэрээр Гоминьданы холбогдох газруудад цахилгаан илгээв. Дөрөвдүгээр сарын 23-нд Бат хаалга сүмд “Монголын орон нутгийн өөртөө засах засгийн явдлын зөвлөл” байгуулагдаж, ёслол хийжээ. Үүнд Шаньси, Суйюань, Цахар мужийн тэргүүлэгчид хувийн төлөөлөгчөө томилон ирүүлж бэлэг сэлт хүргүүлэв. Төвөөс төлөөлөгч биечлэн ирүүлээгүй бөгөөд Бээжингээс Цэргийн явдлын хорооны албан тушаалтанг томилон ирүүлж хянуулсан байна. Хуралд Зөвлөлийн удирдах арван гурван хүнээс гадна чуулган

хошуудын төлөөлөгчид бүгд гурван зуу гаруй хүн оролцжээ. Хурлаас Гоминьданы холбогдох байгууллагуудад цахилгаан илгээв.

Монголын Засгийн явдлын зөвлөл байгуулагдсаны дараа бүх тэнхим, газар, хорооны дарга нарыг томилов. Дэ ванг Нарийн бичгийн тэнхимийн нарийн бичгийн даргаар, Шаравдоржийг Ардыг засах газрын дарга, Буяндалайг Амарыг хамгаалах газрын дарга, Бао Юйчин-г Эдийн засгийн хорооны эрхлэгч гишүүнээр, У Хэлин-г Зөвлөлгөөний тэнхимийн дарга, Пулингааг Сурган хүмүүжлийн газрын даргаар гэх зэргээр олон хүнийг албан тушаалуудад томилов. Өөртөө засах хөдөлгөөнд оролцсон сэхээтнүүдийн олонхийг зөвлөх, хэлтсийн дарга зэрэг албан тушаалуудад томилжээ.

Монголын орон нутгийн өөртөө засах засгийн явдлын зөвлөлийн харьяанд Их зуугийн чуулганы долоон хошуу, Улаанцавын чуулганы зургаа, Цахарын арван хоёр, Шилийн голын арван хошуу орж байлаа. Уг зөвлөл байгуулагдсаны дараа Ёндонванчиг, Содномравдан, Шагдаржав зэрэг дэд дарга нар нас ахисан болохоор сайн ажиллаж чадахгүй байсан тул гол эрхийг үндсэндээ Дэ ван ганцаараа атгасан байна. (7, т.145)

*Үргэлжлэл нь дараагийн дугаарт*

### **Ишлэл, зүүлт**

1. “БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон”. УБ, 1981
2. Дылыков.С.Д. “Өвөр Монголын ардчилсан хөдөлгөөн”. УБ, 1956
3. Дэмчигдонров “Бат хаалга сүмийн Монголын өөртөө засах хөдөлгөөний дурсамж”. Хөххот, 1964
4. Лу Минхуй. “Мэргэнбаатарыг сурвалжилсан тэмдэглэл”. Хөххот, 1973
5. Лу Минхуй. “Сун Юаньфэнг сурвалжилсан тэмдэглэл”. Хөххот, 1975
6. Лу Минхуй. “Ванчигсүрэнг сурвалжилсан тэмдэглэл”. Хөххот, 1975
7. Лу Минхуй. “Монголын өөртөө засах хөдөлгөөний эхлэл төгсөл”. Хөххот, 1986
8. Фэн Фаньзю. “Монголын тойм байдал ба Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн”. Шан У хэвлэлийн хороо, 1974
9. Хуан Фэншэн. “Өвөр Монголын чуулган хошууны өөртөө засах хөдөлгөөний бодит тэмдэглэл”. Зинь хуа хэвлэлийн хороо, 1977
10. Чэнь Шао У. “Дэмчигдонров хийгээд Зян Зиэши-гийн харьцаа”. Өвөр Монголын соёл, түүхийн лавлалтын материал, 1974